



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭС

2018 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“16.ХЭЛЭЛЦСЭН нь:

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бусдаас түрээсэлдэг байр талбайн түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг тогтоох тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бусдаас түрээсэлдэг байр талбайн 1 м.кв талбайн түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг хэлэлцээд дараах арга хэмжээ авч ажиллахыг төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагууд, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүд нарт даалгав:

1.1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын бусдаас түрээсэлдэг байр талбайн 1 м.кв талбайн түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг 30,000.00 (гучин мянган) төгрөгөөс ихгүй байлгах;

1.2.Түрээсийн үйлчилгээний гүйцэтгэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нээлттэй сонгон шалгаруулах;

1.3.Бусдаас байр талбай түрээслэх бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч байх;

1.4.Түрээсийн болон ашиглалтын төлбөрийг холбогдох зардалд тусгасан байх;

1.5.Түрээсийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд байгуулж байх;

2.Энэхүү тэмдэглэлд тусгагдсан асуудлаар чиглэл боловсруулж, бусдаас байр талбай түрээслж үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн дарга Ц.Түвшинзаяад даалгав” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



000221

D:\Huraldaanii material\2018 он\2018.01.09\togtool\01docx